



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Г Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9.2 дахь заалтыг үндэслэн, Эрүүл мэндийн яамны шинэ бүтэц, зохион байгуулалттай холбоотойгоор ТУШААХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх)-ийн шинэчилсэн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж, анагаах ухаан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, шинэ техник, технологийг нэвтрүүлэх цар хүрээг өргөжүүлэх, чанарыг сайжруулахад анхаарч ажиллахыг Зөвлөл, түүний гишүүдэд даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2012 оны 325 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.



147

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 3 дугаар  
сарын **19**-ны өдрийн **28** тоот тушаалын хавсралт

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Дарга: Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9.2-т зааснаар Эрүүл мэндийн сайд
2. Орлогч дарга: Ж.Амарсанаа, эрүүл мэндийн дэд сайд, анагаах ухааны доктор
3. Нарийн бичгийн дарга: Б.Бурмаажав-Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Монголын Анагаах ухааны академийн гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор

Гишүүд:

4. А.Эрдэнэтуюя, Төрийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор
5. Д.Оюунчимэг-Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, анагаах ухааны доктор
6. Ц.Цолмонгэрэл, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Эдийн засгийн ухааны магистр
7. Б.Баярт-Хүний нөөцийн хэлтсийн дарга, Шинжлэх ухааны академи, Монголын Анагаах ухааны академийн гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
8. Я.Амаржаргал-Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга, анагаах ухааны доктор
9. П.Нямдаваа-Шинжлэх ухааны академи, Монголын Анагаах ухааны академийн гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
10. Н.Баасанжав-АУХ-ийн захирал, Шинжлэх ухааны академи, Монголын Анагаах ухааны академийн гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
11. Θ.Ганчимэг-НЭМҮТ-ийн захирал, анагаах ухааны доктор
12. Г.Баясгалан-УХТЭ-ийн дарга, анагаах ухааны доктор
13. Б.Бямбадорж-УНТЭ-ийн дарга, анагаах ухааны доктор
14. Б.Амарсайхан-ЭМШУИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, анагаах ухааны доктор, профессор
15. Ч.Чимэдрагчаа-УАШУТҮК-ийн захирал, анагаах ухааны доктор, профессор